

АГУУЛГА

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	3
1.1 Төсөл хэрэгжүүлэгч байгууллагын мэдээлэл.....	3
1.2 Ордын байршил.....	4
1.3 Төслийн хүчин чадал, техник, технологи.....	4
1.4 Уулын ажлын горим.....	4
1.5 Ашиглалтын технологи, механикжуулалтын бүтэц.....	5
1.6 Уурхайн гадаад, дотоод тээвэр, зам Ухаж-ачих процесс.....	5
1.6.1 Дотоод тээвэр.....	5
1.6.2 Гадаад тээвэр	5
1.7 Үржил шимт хөрс хуулах хэмжээ, хөрсний овоолго, хаягдлын овоолго.....	6
1.7.1 Хөрсний овоолго.....	6
1.7.2 Овоолгын ажлын календарчилсан төлөвлөлт	7
1.7.3 Хаягдлын овоолго	7
1.8 Хуурай аргаар баяжуулах үйлдвэр.....	7
1.8.1 Баяжуулах үйлдвэрийн ажиллах горим.....	8
2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ ОРЧМЫН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГМИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ, ОНЦЛОГ.....	8
2.1 Физик газарзүйн нөхцөл.....	8
2.2 Уур амьсгал.....	9
2.3 Агаар орчин	9
2.4 Гадаргын ус.....	9
2.5 Газрын доорх ус.....	9
2.6 Хөрсөн бүрхэвч.....	9
2.7 Ургамлан нөмрөг.....	10
2.8 Амьтан	11
2.9 Геоморфологи	11
2.10 Хог хаягдал	11
2.11 Зам.....	11
3. 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	12
3.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	12
3.2. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө.....	13
3.3. Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөө.....	14
3.4. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө.....	14

3.5. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн төлөвлөгөө.....	15
3.6. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө.....	16
3.7. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө.....	16
3.8 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний 2022 төсөв.....	16

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1.1 MV-10665 тоот тусгай зөвшөөрлийн газарзүйн солбицол.....	3
Хүснэгт 1.2 2012-2013 онд олборлосон нөөц.....	4
Хүснэгт 1.3 Ил уурхайн ажлын горим.....	4
Хүснэгт 1.4 Уурхайн ашиглалтын технологи	5
Хүснэгт 1.5 Хуулах шимт хөрсний хэмжээ /ашиглалтын жил бүрээр/	5
Хүснэгт 1.6 Овоолгын үндсэн хэмжээ	6
Хүснэгт 1.7 Хөрсний овоолгын төлөвлөлт	7
Хүснэгт 1.8 Тоног төхөөрөмжийн нэгдсэн хүснэгт.....	8
Хүснэгт 1.9 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	12
Хүснэгт 1.10 Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө.....	13
Хүснэгт 1.11 Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөө.....	14
Хүснэгт 1.12 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө.....	14
Хүснэгт 1.13 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн төлөвлөгөө.....	15
Хүснэгт 1.14 Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө.....	16
Хүснэгт 1.15 Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө.....	16
Хүснэгт 1.16 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний 2022 төсөв.....	16

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1.1 Уурхайн сансраас харагдах байдал.....	3
---	---

НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1 Төсөл хэрэгжүүлэгч байгууллагын мэдээлэл

Дундговь аймгийн Говь-Угтаал сумын нутагт орших MV-010665 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий “Хараат-Уул” нэртэй цайр, төмрийн ордын ашиглалтын тусгай зөвшөөрлийг 2008 оны 03 сарын 07-ны өдөр “Шанжин-Орд” ХХК шилжүүлэн авсан.

Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж, байгууллагын нэр, хаяг: “Шанжин орд” ХХК, Улсын бүртгэлийн дугаар-9019037017, регистрийн дугаар-5197325. Хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 6-р хороо, 10-р хороолол, “Жөн-Юан” ХХК-ийн байр, 2-р давхар.

Төслийн зорилго: Цайр, төмрийн хүдрийг олборлон, боловсруулж эдийн засгийн эргэлтэд оруулахад төслийн зорилго оршино.

1.2 Ордын байршил

Ордын талбай нь Дундговь аймгийн Говь-Угтаал сумаас зүүн урагш 26 км-т, Чойр төмөр замын өртөөнөөс 65 км-т, Улаанбаатар хотоос зүүн урагш 268 км-т Мандалговь хотоос зүүн тийш 160 км-т дэд бүтэц харьцангуй сайн хөгжсөн районд байрлана.



Зураг 0.1 Уурхайн сансраас харагдах байдал

Хүснэгт 0.1 MV-10665 тоот тусгай зөвшөөрлийн газарзүйн солбицол

№	Уртраг	Өргөрөг
1	107° 45' 21.57"	45° 58' 41.61"
2	107° 44' 41.56"	45° 58' 41.61"
3	107° 44' 41.56"	45° 59' 11.61"
4	107° 45' 21.57"	45° 59' 11.61"

1.3 Төслийн хүчин чадал, техник, технологи

Ордын нөөцийн баталгаажуулалт Хараат-Уулын цайр, төмрийн хүдрийн ордын нийт нөөцийг 63.78 сая.тн, үүнээс бодитой (В) нөөцийг 22.88 сая.тн, боломжтой (С) нөөцийг 14.86 сая.тн, таамаг (Р) нөөцийг 26.036 сая.тн-оор тус тус тогтоож Монгол улсын ашигт малтмалын нөөцийн нэгдсэн тоо бүртгэлд бүртгүүлсэн. Уурхайг ашиглах төслийн хугацаанд нийт 1,967.7 тэрбум төгрөгийн борлуулалтын орлого олж, 1,440.7 тэрбум төгрөгийн үйл ажиллагааны зардал гарган, 527.0 тэрбум төгрөгийн татварын өмнөх ашигтай ажиллагаар байна. Татвар ногдуулсны дараах байдлаар нийт 401.5 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай, 431.5 тэрбум төгрөгийн үйл ажиллагааны мөнгөн урсгалтай ажиллагаар байна. Энэхүү төслийг ашиглаж эхэлснээр удирдлага, уурхайн удирдлага, ил уурхай, баяжуулах хэсэг, гадаад тээвэр, захиргаа аж ахуй зэрэг хэсгүүдэд нийт 80 хүнийг ажлын байраар хангах 1 ажилчны сарын дундаж цалин 1,227 мян.төг байна. Ил уурхайн жилийн хүчин чадал ойролцоо буюу 1.3-1.4 сая.тн хүдэр байгаа тул төсөлд 1.35 сая.тн-оор тооцов. Уулын ажлын календарчилсан төлөвлөгөөг 1350.0 мян.тнын хүчин чадалтайгаар 14 жил ашиглахаар төлөвлөвөө. 2012-2013 онд олборлолт явуулж 266.2 мян.тн хүдийг овоолгод хураасан бөгөөд уг ашиглалтын эхний жил уг нөөц ХБҮ-т баяжуулагдана. Уурхай нь ашиглалтын 14 жилийн хугацаанд нийт 18.2 сая тонн хүдэр олборлон боловсруулж, 55 хувийн агуулгатай төмрийн хүдрийн баяжмал 3.2 сая тонн, 63.4 хувийн агуулгатай төмрийн хүдрийн баяжмал 5.9 сая тонн, 45.3 хувийн агуулгатай цайрын баяжмал 220.0 мян.тн үйлдвэрлэн борлуулна.

Хүснэгт 0.2 2012-2013 онд олборлосон нөөц

Ашиглалтын жилүүд	2012-2013 онд олборлосон нөөц				
	Хүдэр тн	Агуулга, %		Металлын нөөц, тн	
		Fe	Zn	Fe	Zn
В	154,833.7	20.57	0.99	31,843.2	1,532.7
С	111,386.5	19.94	0.97	22,207.8	1,081.3
Нийт	266,220.2	20.30	0.98	54,051.0	2,614.0

1.4 Уулын ажлын горим

Уулын ажил жилд 10 сар үргэлжлэх ба үйлдвэрлэлийн үндсэн процессууд нь тасралтгүйгээр өдөрт 2 ээлжээр 12 цагаар үргэлжилнэ.

Хүснэгт 0.3 Ил уурхайн ажлын горим

Үзүүлэлт	Х.нэгж	Хоног
Жилд ажиллах өдөр	хоног	300
Жилд ажиллах сар	сар	10
Ээлжийн үргэлжлэх хугацаа	цаг	12
Ээлжийн тоо	ээлж	2
Баяр ёслолоор амрах өдөр	хоног	11
Цаг агаарын саатлаас сул зогсох хугацаа	хоног	6
Бэлтгэл ажилд зарцуулах хугацаа	хоног	2

Жилд ажиллах хоног	хоног	281
--------------------	-------	-----

1.5 Ашиглалтын технологи, механикжуулалтын бүтэц

Шимт хөрсийг 0.2 метр зузаантай хуулж шимт хөрсний овоолгод хадгалах ба үндсэн хөрс болон хүдрийг өрөмдлөг тэсэлгээний ажлаар сийрэгжүүлж, экскаватор – автосамосвалын хослолоор ухаж-ачиж тээвэрлэн хөрсний гадаад овоолго болон хүдрийг бутлан ангилах хэсгийн талбайд тус тус хураана.

Хүснэгт 0.4 Уурхайн ашиглалтын технологи

Технологи	Үндсэн ажил	Технологийн процессууд
Авто тээвэртэй ашиглалтын технологи	Хөрс хуулалт	Ухаж ачих Тээвэрлэх Овоолох
Хүдэр олборлолт	Өрөмдлөг, тэсэлгээ Ухаж ачих Тээвэрлэх	

1.6 Уурхайн гадаад, дотоод тээвэр, зам Ухаж-ачих процесс

Уурхайн жилийн хүчин чадал болон цаг ашиглалт, экскаваторын тээврээр хангагдах нөхцөл зэргээс хамаарсан экскаваторын оновчтой утгуурын багтаамж нь тооцоогоор хөрсөнд 2.5 м³ хүдэрт 2.4 м³ байна. Иймд манай орны эрс тэс нөхцөлд найдвартай ажиллагаатай, бүтээл өндөр зэргийг харгалзан CAT-349L маркийн экскаваторыг ашиглана.

1.6.1 Дотоод тээвэр

ТЭЗҮ тусгаснаар уулын ажлын календарчилсан төлөвлөгөөний дагуу жилд дунджаар 430.0 мян.м³ хөрс хуулж, 1350.0 мян.тн хүдэр олборлоно. Ил уурхайн автосамосвалын тооцоо: манай орны нөхцөлд өргөн ашиглагддаг, бүтээл өндөртэй SINOTRUCK ZZ3317N2861 маркийн автосамосвалыг хөрс болон хүдэр тээвэрт ашиглана.

1.6.2 Гадаад тээвэр

Баяжуулах үйлдвэрээс гарсан хүдрийн баяжмалыг YTO ZL50F утгуурт ачигчаар North Benz ZZ5807N3641 маркийн автосамосвалд ачин төмөр замын Чойр өртөө хүртэл 65 км зайнд тээвэрлэнэ. Өртөөнөөс цааш төмөр замаар тээвэрлэнэ. SINOTRUCK ZZ3317N2861 маркийн автосамосвалыг хөрс болон хүдэр тээвэрт ашиглана.

1.7 Үржил шимт хөрс хуулах хэмжээ, хөрсний овоолго, хаягдлын овоолго

Үржил шимт хөрс буюу газрын гадаргаас ойролцоогоор 0.2 м орчим зузаантайгаар хуулж шимт хөрсний овоолгод байршуулна. Ил уурхайн ашиглалтын хугацаанд 122.17 мян.м³ шимт хөрс хуулж овоолгод байршуулахаар байна.

Хүснэгт 0.5 Хуулах шимт хөрсний хэмжээ /ашиглалтын жил бүрээр/

Тынжилүүд	Ил уурхайн эвдрэлд өртөх талбай, м ²	Овоолгн суурь, м ²	Зам талбай, м ²	Тосгон, м ²	Баяжуулх хэсэг, м ²	Нийт эвдрэлд өртөх талбай, м ²	Хуулах шимт хөрсний хэмжээ, м ³
2024 он	33400	13600	6149.6	-	13.634.2	47400	10254.16

Ил уурхай нь 2024 оны хугацаанд уурхайн олборлолтод хамаарах 3.34 га хөрсний овоолгын 1.36 га, баяжуулахын овоолгын 1.36 га талбайн шимт хөсийг хуулж нийт 12.33 мян.м3 шимт хөрсийг овоолгод байршуулахаар байна.

1.7.1 Хөрсний овоолго

Ашиглалтын хугацаанд нийт 6.035 сая.м3 хөрс хуулж хөрсний гадаад овоолгод байршуулна. Салхины чиглэл, газрын гадаргын хэлбэржилт зэргийг харгалзан үзэж 2 уурхай дундаа нэг овоолготой байхаар төлөвлөж баруун урд талд 150 м зайд байгуулахаар төлөвлөв.

Овоолгын үндсэн хэмжээс, загвар: Чулуулгийн тогтворжилт, уурхайн нөхөн сэргээлтийн бодлогоос хамааруулж овоолгын 3 ярустай, суурийн ярусын өндөр дунджаар 30 м, дээд ярусын өндөр 20 м байна. Доголын хажуугийн өнцгийг 34 градус байхаар төлөвлөсөн.

Овоолгын ажлын календарчилсан төлөвлөлт

Ашиглалтын нийт хугацаанд уурхайгаас нийт 6.035 сая.м3 хөрс хуулж хөрсний чулуулаг гадаад овоолгод шилжүүлнэ. Хөрсийг өрөмдлөг тэсэлгээний ажлаар сийрэгжүүлэн, автосамосвалаар тээвэрлэж гадаад овоолгод хураах ба уг процессын үр дүнд хөрс 20%-иар сийрэгжинэ. Ил уурхайн хөрс хуулалтын төлөвлөгөөг дараах хүснэгтэд үзүүлээ.

Хүснэгт 0.6 Овоолгын үндсэн хэмжээ

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Утга
1	Овоолгын доголын өндөр	м	20-35
2	Овоолгын доголын тоо	ш	3
3	Овоолгын замын өргөн	м	20
4	Овоолгын замын налуу	промил	90
5	Овоолгын эзлэх талбай	га	25.6

1.7.2 Овоолгын ажлын календарчилсан төлөвлөлт

Ашиглалтын нийт хугацаанд уурхайгаас нийт 6.035 сая.м3 хөрс хуулж хөрсний чулуулаг гадаад овоолгод шилжүүлнэ. Хөрсийг өрөмдлөг тэсэлгээний ажлаар сийрэгжүүлэн, автосамосвалаар тээвэрлэж гадаад овоолгод хураах ба уг процессын үр дүнд хөрс 20%-иар сийрэгжинэ. Ил уурхайн хөрс хуулалтын төлөвлөгөөг дараах хүснэгтэд үзүүлээ.

Хүснэгт 0.7 Хөрсний овоолгын төлөвлөлт

Ашиглалтын жилүүд	Хуулах хэмжээ, м3	хөрсний	Сийрэгжсэнээр, м3	Өсөх нийлбэрээр, м3
1		399,206.67	479,048.00	479,048.00
2		455,250.80	546,300.96	1,025,348.97
3		474,219.59	569,063.50	1,594,412.47
4		424,642.08	509,570.50	2,103,982.97
5		476,375.13	571,650.16	2,675,633.12
6		447,059.74	536,471.68	3,212,104.81
7		441,886.43	530,263.72	3,742,368.53
8		431,108.71	517,330.46	4,259,698.98
9		444,473.08	533,367.70	4,793,066.69
10		431,970.93	518,365.12	5,311,431.80
11		437,359.79	524,831.75	5,836,263.55
12		438,006.45	525,607.74	6,361,871.30
13		392,308.93	470,770.72	6,832,642.01
14		341,653.66	409,984.39	7,242,626.40
Нийт В		6,035,522.00	7,242,626.40	7,242,626.40

1.7.3 Хаягдлын овоолго

“Хараат-Уул”-ын ордод усны асуудал шийдэгдээгүй байгаатай холбоотойгоор эхний 5 жилд хуурай соронзон баяжуулалт хийгдэх бөгөөд хаягдал буюу бага агуулгатай хэсгийг агуулахад хураана.

1.8 Хуурай аргаар баяжуулах үйлдвэр

1.8.1 Баяжуулах үйлдвэрийн ажиллах горим

Баяжуулах үйлдвэрийн ажиллах горимыг ихэнхи баяжуулах үйлдвэрүүдийн жишгийг харгалзан үзэж дараах байдлаар сонгов. Үүнд:

- Жилийн /календарийн/ 365 хоног
- Тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ 10 хоног
- Төлөвлөгдөөгүй сул зогсолт 10 хоног
- Жилд ажиллах хоногийн тоо 340 хоног
- Хоногт ажиллах ээлжийн тоо 3
- Ээлжийн үргэлжлэх хугацаа 8 цаг

Баяжуулах үйлдвэрийн хүдэр бэлтгэх /бутлах цех/ нь жилд 340 хоногт 3 ээлж, 1 ээлж нь 6 цагаар ажиллана. Тоног төхөөрөмжийн жилд ажиллах хугацаа жилд 6120 цаг, тоног төхөөрөмжийн найдварт ажиллагаа 69,86%. Баяжуулах үйлдвэрийн төв корпус /нойтон баяжуулах үйлдвэр/ нь жилд 340 хоногт 3 ээлж, 8 цагаар ажиллана. Тоног төхөөрөмжүүдийн ажиллах хугацаа жилд 8160 цаг, төхөөрөмжийн найдварт ажиллагаа 93,15%.

Хуурай баяжуулах үйлдвэр нь хүдрийг 3 шатны бутлалт, 1 шатны шигшилт бүхий битүү циклээр хүдрийг 10 мм хэмжээтэй болгон буталж 3 шатны хуурай соронзон баяжуулалтаар оруулан 55,3%-ийн агуулгатай төмрийн баяжмал гарган авахаар төлөвлөн тооцоог хийлээ. Хуурай баяжуулалтаас гарах хаягдлыг овоолго үүсгэн нойтон баяжуулах үйлдвэр ашиглалтад орох хүртэл хадгална.

Хүснэгт 0.8 Тоног төхөөрөмжийн нэгдсэн хүснэгт

№	Тоног төхөөрөмж	Тоо ширхэг	Марк
1	Хацарт бутлуур	1	HJC80
2	Дунд шатны конусан бутлуур	1	WKS 250-B
3	Жижиг шатны конусан бутлуур	1	WKS 75-B
4	Шигшүүр	1	2ZY1860
5	Хуурай соронзон сепаратор	3	CTDG0808
6	Нийт	7	-

2 ТӨСЛИЙН ТАЛБАЙ ОРЧМЫН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГМИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ, ОНЦЛОГ

2.1 Физик газарзүйн нөхцөл

Хараат-Уулын цайр, төмрийн орд нь Дундговь аймгийн Говь-Угтаал сумаас зүүн урагш 26 км-т, Чойр төмөр замын өртөөнөөс 65 км-т, Улаанбаатар хотоос зүүн урагш 268 км-т Мандалговь хотоос зүүн тийш 160 км зайд байрлана. Хэнтийн уулархаг мужийн өмнөд төгсгөл, тал хээрийн бүсэд хамаарагдана. Хамгийн өндөр уулсын хувьд Холбоо чулуу уул, Бага бор уул, Их бор уул зэрэг нь далайн түвшнээс дээш 1500м орчим байх ба уулархаг мужийн үнэмлэхүй өндөр нь 1200-1400м, харьцангуй дундаж өндөр нь 100-150м байна. Өндөр уулс нь боржингийн биетүүдээс тогтох ба орой нь шовх, бөмбөгөрдүү бөгөөд нарийн гуу, жалга ихтэй, хадан цохио элбэгтэй, тал хөндий нь дов толгодлог, гүвээ судаг ихтэй, өргөн, тэгш гадаргуутай.

2.2 Уур амьсгал

Эх газрын эрс тэс уур амьсгалтай ба олон жилийн сарын дундаж температураар 7-р сард хамгийн дулаан +30.4, +35.9 хэм, 1-р сард хамгийн хүйтэн -24, -34 хэмд хүрдэг байна. Жилийн дундаж хур тунадас зуны улиралд 150-200 мм ба нийт тундасны 75% нь 7- 9-р саруудад буудаг. Өвлийн улиралд 75-125мм 10-р сарын дунд үеэс 2-р сар хүртэл алаг цоог цасан бүрхүүлтэй газрын хөрс 1.2м хүртэл хөлдөнө. Төсөл хэрэгжих нутагт олон жилийн дундажаар салхины хурд 3,5 /сек байна.

2.3 Агаар орчин

Төслийн ТЭЗҮ-ийн мэдээлэл болон эх үүсвэрийн ялгарлын холбогдох гарын авлагуудын арга зүйг ашиглан тооцоолол хийж тархалтын загвараар уурхайн агаар бохирдуулагч бодисын нөлөөллийг тооцоолсон. Тархалтын загварын үр дүнгээс үзэхэд төслийн гол агаар бохирдуулагч бодис болох тоос тоосонцор уурхайн овоолгын үйл ажиллагаа болон гадаад дотоод тээвэрлэлтээс үүсэх бохирдуулагч стандарт хэмжээнээс их байж болзошгүй байна. Уурхайн ухаш олборлолт болон баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаанаас үүсэх тоос, тоосонцор стандартын ЗДХ-д орчны агууламжийг нэмэгдүүлж байна. “Шанжин орд” ХХК-ийн зүгээс тоос, тоосонцор дарах усалгааг тогтмол хийх, тоосжилт бууруулах зааварчлагаанд дурдсан арга хэмжээг авж ажиллах шаардлагатай.

2.4 Гадаргын ус

Уурхайн ойр орчимд гадаргын ус (гол, горхи, нуур) байхгүй. Уурхайн ойролцоо олон тооны жижиг сайрууд байх боловч тэнд байнгын урсгал ус байдаггүй зөвхөн их устай ширүүн бороотой үед тэдгээрээр үерийн ус урсаж өнгөрдөг байна. Хараат-Уулын ордын орчимд 4-5 гар худаг байх ба тэдгээрийн гүн нь 1-8 м байдаг. 5. Төмрийн хүдрийг хуурай аргаар баяжуулахад техникийн зориулалттай усны хэрэглээ гарахгүй ба уурхайн кемпед шаардагдах унд ахуйн цэнгэг усны хэрэглээ болон

2.5 Газрын доорх ус

Төмрийн хүдрийг хуурай аргаар баяжуулахад техникийн зориулалттай усны хэрэглээ гарахгүй ба уурхайн кемпед шаардагдах унд ахуйн цэнгэг усны хэрэглээ болон зам талбай, ногоон байгууламж, гал унтраах зэрэгт ашиглах техникийн усны хэрэглээ нийлээд 52.0 м³/хоног байна гэж тооцсон. 0.6 – 0.8 л/с ундаргатай ашиглалтын 2 худаг тус бүрийг хоногт 20-20 цаг ажиллуулна гэж үзвэл тэдгээрээс хоногт дунджаар 100 м³ ус авахболомжтой юм.

2.6 Хөрсөн бүрхэвч

Байгалын бүсээр хээрийн бүсийн гандуу хээрийн дэд бүсэд хамаарах бөгөөд хөрс-газарзүйн мужлалтаар цайвар хүрэн хөрсний дэд бүс Баяндэлгэрийн 8-р тойрогт багтана. Эндэхийн ургамалшил тачир сийрэг зарим газраа ургамалгүй цулгүй байдаг учраас салхины үйлчлэлд хялбар өртөж хөрсний өнгөн хэсэг салхинд хийсч эвдрэх үйл явц элсэнцэр хөрстэй газраар байнга ажиглагдана. Орд орчмын газраар агь үетэн голлосон хуурай хээрийн ургамалшил зонхилж бүрхэц нь 20-40% хүрнэ. Энд сайргархаг болон карбонаттай цайвар хүрэн, хужирлаг шинжтэй цайвар хүрэн хөрс голлох суурийг эзлэхийн хамт гүвээ толгодоор нимгэн чулуурхаг цайвар хүрэн хөрс элбэг тархах ба толгодын орой бэлээр алаг цоог том валун чулууны илэрцтэй. Энд сайргархаг болон карбонаттай цайвар хүрэн, хужирлаг шинжтэй цайвар хүрэн хөрс голлох суурийг эзлэхийн хамт гүвээ толгодоор нимгэн чулуурхаг цайвар хүрэн хөрс элбэг тархах ба толгодын орой бэлээр алаг цоог том валун чулууны илэрцтэй. Цайвар хүрэн хөрс өвөл 2,5 3 м хүртэл гүн хөлдөх ба зун хур борооны ус хөрсөнд дөнгөж 15-20 см гүн нэвчиж чийглэгддэг онцлогтой.

2.7 Ургамлан нөмрөг

Дундговь аймгийн Говь-Угтаал сум нь Н.Өлзийхутагийн (1989) ангилсан ургамал-газарзүйн мужлалын 16 тойргийн Дундад Халхын хээрийн тойрог, Дорноговийн цөлөрхөг хээрийн тойрогт багтдаг боловч “Хараат уул”-ын цайр, төмрийн орд нь Дундад Халхын хээрийн тойрогт хамаарагдах бөгөөд талбайн ургамлан нөмрөгийн хувьд хээрийн ургамал зонхилон тохиолдох бөгөөд өвслөг ургамлаас крыловын Хялгана / *Stipa krylovii* /, сөөглөг ургамлаас бяцхан навчит Харгана / *Caragana microphylla* / ургамлаас хагас сөөгөнцөр ургамлаас агь Шарилж / *Artemisia frigida* / зэрэг ургамлууд зонхилон ургадаг.

2.8 Амьтан

“Хараат-Уул”-ын орд газар болон түүний орчмын нутгаас судалгааны явцад 5 багт хамаарах 16 зүйл тэмдэглэгдсэнээ шавьж идэштэн 1, далавчтан 3 махчтан 3 туулайтан 2, мэрэгчтэн 7 зүйл байна..

2.9 Геоморфологи

Говь-Угтаал сум нь говь, тал хээрийн бүсийн довтолгод голдуу 207,7 мянган га талбай бүхий нутаг дэвсгэртэй бөгөөд элс чулуурхаг хүрэн, хужир мараат хөрс бүхий талархаг гадаргатай. Ерлөг /1706м/ Их газрын чулуу /1566м/ Баянзүрх /1648м/ Их-Угтаал /1673м/ Сүмбэр цагаан уул /1408/ Хараат /1521м/ Цац /1469м/ Хонгор, Залаа, Даш-яйчил, Дулааны уул, Бичигтийн цохио, Их бага тал зэрэг уул тал хосолсон нутагтайгаас гадна, Сүмбэрийн цайдам говь, Шар, Бор Даравгай гурван дэлгэрийн тойром бүрд нуур Сүмбэрийн булаг, Баянбулаг, Дунд булаг, Могойн булаг, Цавчирын булаг Тал булаг зэрэг ундармал булаг шандуудтай. Хазаар өвс, хялгана ерхөг агь ганга таана хөмүүл дэрс бут хиаг зэрэг ургамалтай. Болор гартаам мана, хаш зэрэг эрдэнийн чулуу, Чулуун нүүрс, төмрийн хүдэр хайлуур жонш шохойн чулуу цайр мөнгө бал чулуу цахиур зэс зэрэг ашигт малтмалын илэрцүүд тогтоогдсон байдаг байна.

2.10 Хог хаягдал

Уурхай болон баяжуулах үйлдвэрт 80 хүн ажиллана гэж үзэн 1 хүнээс хоногт дунджаар 0,5 кг хатуу хог хаягдал гарна гэж тооцвол өдөрт 40 кг болно. Одоогийн ахуйн хатуу хог хаягдлын цэгийг шинэчлэн байгуулах шаардлагатай. Шингэн хаягдал хуримтлуулах зориулалттай хөрсөнд үл нэвчих материалаар хийгдсэн цооногийг уурхайн ажилчдын хотхонд байгуулж өгсөн байна. Унд ахуйн хэрэглээнээс гарах бохир ус нь бохир усны хоолойгоор дамжиж бохир ус цэвэрлэх системээр ариутгагдана. Өдөр тутмынбохир ус гадагшлуулах хэмжээ нь 8 м³ орчим байна. Хэрэглээнээс гарсан бохир усыг эрх бүхий байгууллагатай гэрээ байгуулан тээвэрлэн зайлуулна.

Хуурай баяжуулах үйлдвэрийн технологийн үйл ажиллагааны явцад бүтээгдэхүүний чанарыг хянах шинжилгээний лабораторид ашиглах хүчлүүд (хүхрийн, фосфорын, азотын ба давсны), натрийн пероксид, натрийн вольфрамат, зэсийн сульфат зэрэг 7 нэрийн химийн бодис ашиглана. Эдгээр бодисууд дотор Монгол улсад ашиглахыг хориглосон, хязгаарласан (Засгийн газрын 2007 оны 95 дугаар тогтоол) бодисын жагсаалтанд орсон бодис байхгүй. Харин Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Эрүүл мэндийн сайдын 2009 оны 04/04 дугаар хамтарсан тушаалын 3 дугаар хавсралт болон Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд, Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 10 дугаар сарын 08 -ны өдрийн А/356/396 хамтарсан тушаалын 3 дугаар хавсралт ёсоор аюултай бодисын ангилалд хамаардаг бодисууд байна.

2.11 Зам

Төсөл хэрэгжүүлэгчийн зүгээс Засгийн газрын 2018 оны 379 дүгээр тогтоолоор батлагдсан “Тусгай зориулалтын авто зам, замын байгууламж барих, ашиглах журам”-ын дагуу гадаад тээврийн авто замын чиглэл, ТЭЗҮ-ийг батлуулан тухайн авто зам, замын байгууламжийг барих, ашиглах гэрээг авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай байгуулан ажиллах нь зүйтэй.

СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 1.9

№	Сөрөг нөлөөллийг бууруулах арилгах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал мян.төг	Тоо хэмжэ э	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах эрхзүйн бичиг баримт
Агаарын чанар								
1	Уурхайн технологийн замаас үүсэх тоосжилтыг бууруулах зорилгоор усалгаа хийх, хуурай баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаанаас үүсэх тоосжилтонд хяналт тавих, мананжуулах төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангаж ажиллах	Уурхай доторх зам, баяжуулах үйлдвэр	ш	-	1	5000	2024	“Агаарын тухай”, MNS 0017-2-3-16:1998 (суурьшлын хэсгүүдэд) MNS 4585:2008 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага.
2	Уурхайн бүх машин механизмд үзлэг оношилгоо хийлгэх	Уурхайн бүх автомашин	ш	100	11	1100	Техникийн үзлэг оношилгооны хуваарь дагуу	Агаарын тухай хууль 9, 11, 23-р зүйл MNS 4585:2007 MNS 5919:2008
Гадаргын ба газрын доорхи усны нөөц								
3	Гүний 2 худгийн мониторингийн судалгааг тогтмол хийх, усны чанар өөрчлөлтийг судалж, Уст цэгүүдийг цэвэрлэх арга хэмжээг зохион байгуулах	Гүний худгуудад усны хатуулгыг бууруулах цэвэршүүлэх төхөөрөмж суурилуулах	ш	1000.0	2	2000.0	2024	Усны тухай хууль, MNS 0900:2015
4	Худгуудад ашиглагдаж байгаа тоолуурыг шинэчлэх	Гүний усны ашиглалтын үеийн	Ш	500.0	2	1000.0	2024	Усны тухай хууль

Хөрсөн бүрхэвч								
5	Үржил шимт хөрсийг стандартын дагуу хуулж, хадгалах ба уг үйл ажиллагаанд хяналт тавих. 2024 оны нийт хугацаанд 12.32 мян.м3 үржил шимт хөрс хуулна.	Шимт хөрсний овоолго	га	-	4.8	Хөрс хуулалтын зардал	2024	Хөрс хамгаалах цөлжилтөөс сэргийлэх тухай хууль
6	Ахуйн хатуу, шингэн хог хаягдал болон химийн бодисыг эмх цэгцтэй хадгалах, устгах, зайлуулах, тогтмол хяналт тавиж ажиллах, олон салаа зам гаргахгүй байх. Түлш, шатах тослох материалаар хөрс бохирдохоос урьдчилан сэргийлэх, асгаралт үүссэн талбайг цэвэрлэх, хөрсийг саармагжуулах бодис материалыг авах.	Уурхайн талбайд хэрэгжих төслийн хүрээнд	ш	500.0	2	1000.0	2024	Газрын тухай хуулийн 50-р зүйл 50.1.1 дэх заалт
Амьтны аймаг								
7	Биотехникийн арга хэмжээ авах Зэрлэг ан амьтдад өвөс тэжээл тавьж өгөх	Төслийн талбай орчим болон бага газрын чулуунд	Боодол	20.0	200.0	2000.0	2024	Амьтны тухай хууль
Нийт						12000.0		

БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 1.10

№	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрхзүйн бичиг баримт
1	“Нэг Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд Ашиглалтын талбайд тарих	Уурхайн талбайд: 1-45°59'17.60"N 107°45'7.61"E 2-45°59'16.90"N 107°45'29.89"E 3-45°59'26.48"N 107°45'22.27"E	Ширхэг	5000.0	500	2500.0	2024	“Ургамал хамгааллын тухай” хууль: Зүйл 8-1, 2 Байгалийн ургамлын тухай” хууль: Зүйл 7. Ургамлыг хамгаалах; MNS 5918:2008 “Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн ерөнхий шаардлага
2	Төслийн нөлөөлөлд өртсөн газартай экологийн хувьд ижил нөхцөлтэй газар, тухайн нутаг дэвсгэрийн засаг захиргааны хилийн дотор биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалалт хийнэ.	Хараат уулын уурхайн орчим болон орон нутагт дүйцүүлэн хамгаалах талбай сонгох	га	5000.0	0.5	5000.0	2024	БОНХАЖЯ-ны сайдын 2014-01-10-ны өдрийн А11 тушаалын 2-р хавсралт, 3-р хэсэг. БОНУ-ний аргачлал. БО-ыг хамгаалах тухай хууль. 31-р зүйл. Аж ахуйн нэгж байгууллагын үүрэг. ХХЦСтухай хууль MNS 5973 : 2009 MNS 6258 : 2011
Нийт						7500.0		

ОСОЛ, ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 1.11

№	Урьдчилан сэргийлэх арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал мян.төг	Нийт зардал	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрхзүйн бичиг баримт

Хараат-Уул цайр, төмрийн ордыг ашиглах, хуурай аргаар баяжуулах үйлдвэрийн төслийн 2024 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө

1	ХАБЭА-н дүрэм, Галын аюулаас хамгаалах, Аваар устгах төлөвлөгөөг ажилчдад танилцуулж шалгах, ХАБЭА-н сургалт хийх	Уурхайн ажилчдад	4	-	ХАБ-ын зардал	2024	Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны тухай хууль, MNS ISO 45001:2019
2	Ажилчин нэг бүрийг хөдөлмөр хамгааллын хувцас, багаж хэрэгслээр хангах	Уурхайн ажилчдад	50	-	-	2024	Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны тухай хууль, MNS 4990:2015

ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 1.12

№	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрхзүйн бичиг баримт
1	Аюултай хог хаягдалыг түр хадгалах цэгийг засаж сайжруулах	Уурхайн орчимд	ш	500.0	1	500.0	2024	Хог хаягдлын тухай хууль
2	Аюултай хог хаягдлын бүртгэлийг тогтмол хийх, гэрээ байгуулсан байгууллагад хүлээлгэн өгөх	Уурхай дээрх аюултай хог хаягдлыг тээвэрлэх	ш	1000.0	-	1000.0	2024	Хог хаягдлын тухай хууль
3	Хог хаягдлын гэрээг Говь-Угтаал сумын ЗД-тай байгуулах төлбөр төлөх	Төслийн хэмжээнд		3000.0	-	5000.0	2024	
	Нийт					7000.0		

ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 1.13

№	Шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал төг	Нийт зардал төг	Тайлбар	Баримтлах стандарт аргачлал
Агаарын шинжилгээ								

Хараат-Уул цайр, төмрийн ордыг ашиглах, хуурай аргаар баяжуулах үйлдвэрийн төслийн 2024 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө

1	Агаар дахь тоосжилтын хяналт: Нийт тоос PM2.5, PM10	Бохирдуулагч эх үүсвэрүүдийн орчинд	Жилдээ	2	600.0	1.200.0		MNS 4585:2016
2	Агаар дахь хүлцэх агууламжийг тодорхойлох NO _x SO _x CO _x	Бохирдуулагч эх үүсвэрүүдийн орчинд	Жилдээ	2	600.0	1.200.0		MNS 4585:2016
Дуу шуугиан								
2	Дуу шуугиан чичиргээ	Тээврийн замын дагуу	Жилдээ	2	400.0	800.0		MNS 4585:2016
Газрын доорхи ус								
3	Усны чанарын стандартад заасан үзүүлэлтүүд	Уурхайд ашиглагдаж буй худаг ба малчдын ойр орчмын худгууд	Жилдээ	2	200.0	400.0		MNS0900:2015
Хөрсөн бүрхэвч								
4	Хөрсний эвдрэл гэмтэл	Уурхайн орчимд гол замууд	Жилдээ	2	1.500.0	3.000.0		MNS5546:2005
Нийт						3300.0		

ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 1.14

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь		Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
			2024 он			
			Хагас жил	Бүтэн жил		
1	Байгаль орчныг хамгаалах, уурхайн бүтээн байгуулалттай холбоотой дэд бүтцийг сайжруулах, ажлын байр нэмэгдүүлэх, нийгмийн хариуцлагын хүрээнд орон	-	50%	50%	Төсөл хэрэгжүүлэгч байгууллага	

Хараат-Уул цайр, төмрийн ордыг ашиглах, хуурай аргаар баяжуулах үйлдвэрийн төслийн 2024 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө

	нутагтай хамтран ажиллах гэрээг байгуулах					
2	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө, тайлан боловсруулах	4000.0	50%	50%	Төсөл хэрэгжүүлэгч байгууллага	
3	Орон нутаг, аймгийн удирдлагуудад өөрийн үйл ажиллагааны талаар жил бүр танилцуулга хийх	500.0		100%		БОНБҮТХ-14.1.5
	Нийт	4500.0				

ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 1.15

№	БОХТ-ийн биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал.төг	Хариуцан зохион байгуулах ажилтан, албан тушаалтан	Зохион байгуулах газар
1	Төсөл хэрэгжүүлэгч байгууллага, нөлөөллийн бүсийн иргэд	Багийн иргэдийн хурлаар	БОХТөлөвлөгөөний биелэлтийн тайлан	2024 оны багийн иргэдийн хурлын товийн дагуу	2.000.0	Төсөл хэрэгжүүлэгч байгууллагын удирдлага, Байгаль орчны мэргэжилтэн	Төсөл хэрэгжүүлэгч байгууллагад

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2024 ОНЫ НИЙТ ТӨСӨВ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний төсөв

Хүснэгт 1.16

№	Зардлын ангилал	Зардал мян.төг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	12000.0
2	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	7500.0
3	Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөө	ХАБ-ын зардалд
4	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	7.000.0
5	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн төлөвлөгөө	3.300.0
6	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	4500.0
7	Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	2.000.0
	Нийт зардал	36300.0